

Хэрэглэгчдэд зориулсан эм хэрэглэх заавар

Адаптол 300мг хатуу бүрээс (Adaptol 300mg)
Адаптол 500мг шахмал (Adaptol 500mg)

Мебикар (Mebicarum)

Бэлдмэлийг хэрэглэхийн өмнө уг эм хэрэглэх зааврыг анхааралтай уншина уу. Учир нь танд хэрэгтэй чухал мэдээлэл агуулдаг.

- Уг эм хэрэглэх зааврыг хадгалаарай. Учир нь түүнийг дахин унших шаардлага гарч болно.
- Хэрэв танд ямар нэгэн нэмэлт асуулт гарвал эмч болон эм зүйчээс асуугаарай.
- Уг бэлдмэл танд зориулагдсан учир шинж тэмдэг нь таныхтай адил байсан ч бусдад дамжуулж болохгүй. Учир нь тэдэнд хор хөнөөл учруулж болзошгүй.
- Хэрэв танд ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмч буюу эм зүйчдээ мэдэгдээрэй. Үүнд уг эм хэрэглэх зааварт тэмдэглэгдээгүй гаж нөлөө хамаарна.

Уг эм хэрэглэх зааварт:

1. Адаптол гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?
2. Адаптол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?
3. Адаптол бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?
4. Илэрч болох гаж нөлөө
5. Адаптол бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?
6. Савлалтын агууламж болон бусад мэдээлэл

1. Адаптол гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?

Адаптолын үйлчлэгч бодис мебикар нь сэтгэл засах эмийн бүлэгт хамаарагддаг бөгөөд тайван бус байдал, айдас, түгшүүрэл, дотоод сэтгэл хөдлөлийн хүчдэл, цочромтгой байдал зэргийг багасгана.

Бэлдмэлийг хэрэглэх үед булчин сулрахгүй ба хөдөлгөөний зохицуулалтын хямрал илэрдэггүй. Түүнчлэн биеийн хүчний болон оюун ухааны үйл ажиллагааны идэвх дарангуйлагддаггүй. Иймээс бэлдмэлийг ажиллах болон сурах явцыг завсарлахгүйгээр хэрэглэж болно.

Адаптол нь шууд нойрсуулах үйлдэлгүй боловч нойрны эмгэгийн үед нойрсуулах эмийн үйлдлийг дэмжиж нойрсох явцыг хэвийн болгоно.

Мебикар нь тамхинаас гарсны дараа тохиолдох никотин хамааралт байдлыг багасгах буюу арилгана.

Бэлдмэл сэтгэл хөөрөл болон сэтгэл санааг өндөр бодгох үйлдэл үзүүлэхгүй бөгөөд түүний эмчилгээний явцад эмийн хараат байдал, үгүйдлийн хам шинж ажиглагддаггүй.

Адаптолыг дараах эмгэгийн үед хэрэглэнэ.

- Невроз ба невроз төст эмгэг (түгшүүрэл, сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдал, тайван бус байдал, айдас)
- Зүрх судасны өвчинтэй холбоогүй янз бүрийн шалтгаант зүрхний өвдөлт
- Солиорлын эсрэг болон сэтгэл засах эмийн зохимжийг сайжруулах (эдгээр бэлдмэл нь сэтгэлээр унах, хэт тайвшруулах үйлдэл үзүүлдэг ба булчин сульдлыг багасгадаг)
- Тамхи татах хүслийг багасгах бүрдэл эмчилгээнд

2. Адаптол бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?

Бэлдмэлийг дараах тохиолдолд хэрэглэхийг цээрлэнэ.

- Мебикар болон бэлдмэлийн найрлага дахь бусад туслах бодист хэт мэдрэг хүмүүс (6-р хэсэгт жагсаасан)

Анхааруулга ба болгоомжлол!

Адаптолыг хэрэглэхийн өмнө эмч болон эм зүйчтэйгээ ярилцаж зөвлөгөө аваарай.

Хүүхэд ба өсвөр насныхан:

Адаптолыг 18 хүртэл насны хүүхдэд хэрэглэхгүй.

Адаптол ба бусад эмийн бэлдмэл:

Хэрэв та ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэж байгаа, саяхан хэрэглэж дууссан, хэрэглэх гэж байгаа бол энэ тухайгаа эмчлэгч эмч болон эм зүйчид мэдэгдээрэй.

Адаптолыг солиорлын эсрэг эм, сэтгэл засах эм (бензодиазепинууд), нойрсуулах эм, сэтгэл гутралын эсрэг эм, сэтгэц сэргээх эмтэй хамт хэрэглэж болно.

Адаптолыг хоол хүнс, ундаа, согтууруулах ундаатай хамт хэрэглэх нь:

Бэлдмэлийг хоолноос хамааралгүйгээр хэрэглэж болно.

Адаптолыг согтууруулах ундаатай хамт хэрэглэхгүй.

Жирэмсэн ба хөхүүл үе, нөхөн үржих чадварт бэлдмэлийн үзүүлэх нөлөө:

Хэрэв та жирэмсэн болон хөхүүл, өөрийгөө жирэмсэн гэж бодож байгаа, жирэмслэхээр төлөвлөж байгаа бол бэлдмэлийг хэрэглэхээс өмнө эмч болон эм зүйчээс асууж зөвлөгөө авна.

Жирэмсэн болон хөхүүл үед адаптолыг хэрэглэхгүй.

Жолоо барих болон машин механизмтай ажиллах чадварт бэлдмэлийн үзүүлэх нөлөө:

Бэлдмэлийг хэрэглэх үед даралт багасах, сульдах шинж илэрдэг бөгөөд энэ нь тээврийн хэрэгсэл жолоодох болон машин механизмтай ажиллах чадварт нөлөөлж болно.

3. Адаптол бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?

Бэлдмэлийг эмч болон эм зүйчийн зааврыг нарийн баримтлан хэрэглэнэ.

Хэрэв таньд ойлгомжгүй зүйл байвал эмч болон эм зүйчдээ мэдэгдэж шалгаарай.

Бэлдмэлийг хоолноос хамааралгүйгээр хэрэглэнэ.

Насанд хүрэгсдэд 300-500мг тунгаар хоногт 2-3 удаа хэрэглэнэ. 1 удаагийн дээд тунг 3г, хоногийн дээд тунг 10г.

Ээлж эмчилгээ хэдэн өдрөөс 2-3 сар хүртэл хугацаагаар үргэлжилнэ.


Тамхи татах хүслийг багасгах бүрдэл эмчилгээнд хоногт 600-1000мг тунгаар 5-6 долоо хоногийн турш хэрэглэнэ.

Настангуудад тунг зохицуулах шаардлагагүй.

Элэгний дутагдалтай өвчтөнд тунг багасгах шаардлагагүй.

Бөөрний дутагдалтай өвчтөнд тунг тохируулах судалгаа хийгдээгүй. Иймээс эдгээр өвчтөнд болгоомжтой хэрэглэх шаардлагатай.

Бэлдмэлийн үйлдэл хэт хүчтэй, эсвэл хэт сул санагдвал эмчлэгч эмчдээ мэдэгдээрэй.



Хүүхэд ба өсвөр насныхан:

Адаптолыг 18 хүртэл насны хүүхэд, өсвөр насныханд хэрэглэхэд тохиромжгүй.

Тун хэтэрсний улмаас илрэх нөлөө:

Хэрэв та бэлдмэлийн тунг хэтрүүлэн хэрэглэсэн бол яаралтай эмчид мэдэгдэж зөвлөгөө аваарай.

Хэрэв та адаптолыг хэрэглэлгүй мартаж өнгөрөөсөн бол.

Мартаж өнгөрөөсөн тунг нөхөхийн тулд тунг давхарлаж хэрэглэхгүй.

Хэрэв та адаптолын эмчилгээг зогсоох бол.

Хэрэв таньд адаптолыг хэрэглээтэй холбоотой ямар нэгэн нэмэлт асуулт гарвал эмчлэгч эмч болон эм зүйчээсээ асуугаарай.

4. Илэрч болох гаж нөлөө

Бэлдмэлийг хэрэглэх үед бусад эмийн бэлдмэлийн нэгэн адилаар гаж нөлөө ажиглагдах боловч энэ нь бүх хүмүүст илэрдэггүй.

Бэлдмэлийг хэрэглэх үед илрэх гаж нөлөөний давтамжийг дараах байдлаар ангилна.

Байнга илрэх: 10 өвчтөнд 1-с олон тохиолдох.

Олонтаа илрэх: 100 өвчтөнд 1-с олон, 10 өвчтөнд 1-с цөөн тохиолдох.

Хааяа илрэх: 1000 өвчтөнд 1-с олон, 100 өвчтөнд 1-с цөөн тохиолдох.

Ховор илрэх: 10000 өвчтөнд 1-с олон, 1000 өвчтөнд 1-с цөөн тохиолдох.

Маш ховор илрэх: 10000 өвчтөнд 1-с цөөн тохиолдох.

Ховор: цусны даралт багасах, толгой эргэх, хоол боловсруулах замын эмгэг, биеийн хэм багасах, сульдах, өндөр тунгаар хэрэглэх үед харшлын урвал (арьс загатнах) илэрч болно. Харшлын урвал илэрсэн тохиолдолд бэлдмэлийг хэрэглэхээ зогсооно.

Цусны даралт багасах ба биеийн хэм буурсан (биеийн хэм 1-1,5°-р буурч болно) тохиолдолд эмчилгээг зогсоох шаардлагагүй. Цусны даралт ба биеийн хэм нь эмчилгээ дууссаны дараа хэвийн болно.

Ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эм зүйч болон эмчлэгч эмчдээ мэдэгдэж зөвлөгөө авна. Үүнд уг эм хэрэглэх зааварт тэмдэглэгдээгүй ямар нэгэн гаж нөлөө ч мөн хамаарна.

5. Адаптол бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?

Адаптол 500мг шахмал:

25°C-аас доош хэмд хадгална. Чийгнээс хамгаалахын тулд уйлдвэрийн савлагаанд хадгална.


Адаптол 300мг хатуу бүрээс:

25°C-аас доош хэмд хадгална. Чийгнээс хамгаалахын тулд үйлдвэрийн савлагаанд хадгална.

Хүүхэд үзэж хүрэхээргүй газар хадгана.

Цаасан хайрцаг болон блистер дээрх хүчинтэй хугацаа дууссанаас хойш бэлдмэлийг хэрэглэхгүй. Хүчинтэй хугацаа нь тухайн сарын сүүлийн өдөр дуусна.

Ямар нэгэн эмийн бэлдмэлийг бохирын ус болон гэрийн хог хаягдалд хаяж болохгүй. Цаашид хэрэглэхгүй бэлдмэлийг хэрхэн устгах талаар эм зүйчээс асуугаарай. Энэ нь хүрээлэн буй орчныг хамгаалахад тустай.



5. Савлалт ба бусад мэдээлэл

Адаптол бэлдмэлийн найрлага:

Үйлчлэгч бодис: Мебикар.

Бусад туслах бодис: метилцеллюлоза, кальцийн стеарат.

Бүрээсийн бүрхүүлийн найрлага: титанийн диоксид, желатин.

Савлалтын агууламж ба дүрслэл:

Адаптол 500мг шахмал: 10 шахмалыг блистертэй гаргах ба 2 блистерийг (20 шахмал) цаасан хайрцганд савлаж гаргана.

Дүрслэл: цагаан буюу цагаавтар өнгийн, дугуй хэлбэртэй, хавтгай, нэг талд нь хэрчлээс бүхий шахмал.

Хэрчлээс бүхий зураас нь шахмалыг залгихад дөхөм болгоно. Харин 2 тэнцүү хэсэгг хуваахад зориулагдаагүй болно.

Адаптол 300мг хатуу бүрээс: 10 хатуу бүрээсийг блистертэй гаргах ба 2 блистерийг (20 хатуу бүрээс) цаасан хайрцганд савлаж гаргана.

Дүрслэл: Цагаан буюу цагаавтар нунтаг агуулсан, цагаан өнгийн, №0 хатуу царцмаган бүрээс

Нунтгийн хэлбэржүүлэлт буюу хэсгүүдийн бөөгнөрөл нь зөвшөөрөгдөх хэмжээнд байна..

